

**“МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ХХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТОДРУУЛГАД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

**Аудитын код:** САГ-2018/125/-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал  
бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663

Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер С.Оюунгэрэл  
Утас: 261885

Цахим хаяг: [oyungerels@audit.gov.mn](mailto:oyungerels@audit.gov.mn)

Аудитор Д.Цэгмиддорж  
Утас: 261740

Цахим хаяг: [tsegmiddorjd@audit.gov.mn](mailto:tsegmiddorjd@audit.gov.mn)

“Амгалан Ахуй Аудит” ХХК-ийн

Захирал Д.Амгалан

Утас: 77011044

Цахим хаяг: [Amgalanahui.audit@gmail.com](mailto:Amgalanahui.audit@gmail.com)

Чанарын хяналтын мэргэжилтэн: Б.Цэцэгмаа

Утас 77011044

Цахим хаяг: [Amgalanahui.audit@gmail.com](mailto:Amgalanahui.audit@gmail.com)

Аудитор: Б.Буянтэгш

Утас: 77011044

Цахим хаяг: [Amgalanahui.audit@gmail.com](mailto:Amgalanahui.audit@gmail.com)

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ .....	0
2	Аудитын тайлан .....	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	2
2.5	Дотоод хяналт.....	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	3
2.7	Шилэн дансны мэдээлэл .....	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	4
2.9.1	<i>Үндсэн хөрөнгийн талаар</i> .....	4
2.9.2	<i>Мөнгөн хөрөнгийн талаар</i> .....	4
2.9.3	<i>Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар</i> .....	4
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	5
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд .....	5
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	5
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	5
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар: .....	5
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	5
3	Менежментийн захидал .....	7
	Асуудал 1: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар.....	8
	Асуудал 2: Үндсэн хөрөнгийн талаар .....	9
	Асуудал 3: Мөнгөн хөрөнгийн талаар.....	10
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, зорилтот төвшин .....	11
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	12
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.5	Аудит хийгдсэн орлого, зардлын төлөвлөгөө гүйцэтгэлийн тайлан .....	15

“МОНГОЛ ГАЗРЫН ТОС  
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Д.ЦЭРЭННОРОВ ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг, хариуцлага

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн захирал Д.Цэрэнноров танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж хэрэгжүүлэх талаар, үндсэн хөрөнгийн талаар, бэлэг дурсгалын зүйлийн зардлын тухай тогтоол, журам баримтлах талаарх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/ түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн удирдлага жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, НББОУС түүнд нийцүүлэн баталсан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн жилийн эцсийн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс 2018 оны 3 дугаар сарын 08-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 12-нд эцэслэн баталгаажуулж, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн захиралд САГ-2018-/125/СТА-ТӨҮГ



“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

хүргүүлэхээр төлөвлөн, “Амгалан Ахуй Аудит” ХХК-ийн аудитор Б.Буянтэгш, аудиторын туслах Ж.Отгонбаяр нар гүйцэтгэж, аудитын менежер Д.Дэлгэрэхжаргал, захирал Д.Амгалан нар хянан удирдана.

Аудитаар “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 03/319 дүгээр албан бичгээр “Амгалан Ахуй Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

### **2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан гэрээ, зорилтот түвшний үзүүлэлтийг ханган биелүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн, батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн ажилладаг.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн эрхэм зорилго нь Дотоодын түүхий эдийг түшиглэн газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулж, Монгол улсыг газрын тосны бүтээгдэхүүнээр хангаж, газрын тосны болон хими технологийн аж үйлдвэрийн суурийг бий болгоход оршино.

#### **Үйл ажиллагааны стратегийн зорилт:**

Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн төслийн хүрээнд жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах үйлдвэрийг, түүхий тос дамжуулах хоолойн хамт байгуулахад оршино.

#### **“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:**

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагааны чиглэл нь дотоодын түүхий эд, нөөцийг ашиглан газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл хэрэгжүүлэх.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

### **2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС,НББОУС, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний

бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 12 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 20 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Даймонд” програм хангамжаар бэлтгэсэн байна.

## 2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “хэвийн” гэж үзлээ.


## 2.6 Орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК нь 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот төвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 301 дүгээр тогтоолоор 510.9 сая төгрөгийн орлого, 374.0 сая төгрөгийн удирдлагын зардал, 137.0 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны зардалтай ажиллахаар баталсан байна.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн тайлант онд 438.6 сая төгрөгийн нийт төсвийн орлоготой, 391.0 сая төгрөгийн зардалтай, 40.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, 7.5 сая төгрөгийн орлогын албан татварын зардалтай ажилласан байна. Нийт 510.9 сая төгрөг орж ирснээс 438.6 сая төгрөгийг зарцуулж урьдчилж олсон орлогын дансанд 62.3 сая төгрөгийг бүртгэж, 10.0 сая төгрөгийг зээлийн төлбөрт шилжүүлсэн байна. 2017 оны 04 сарын 20-ны өдөр дүрмийн сан бүрдүүлэх зорилгоор 10.0 сая төгрөгний сарын 1.7 хувийн хүүтэй зээлийг хувь хүнээс авсан байна. Уг зээлийн төлбөр 10.0 сая төгрөг болон 0.6 сая төгрөгний хүүгийн төлбөрийн хамт 2017 оны 12 сарын 25-ны өдөр төлж барагдуулсан байна.

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлага, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 4 дүгээр бүлэгт заасныг дагуу шилэн дансны мэдээллийг шалгахад, оруулах шаардлагатай 2 төрлийн мэдээллийг байршуулсан байна.



## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 12 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 20 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

### 2.9.1 Үндсэн хөрөнгийн талаар

Тухайн байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 6.5 сая төгрөгийн өртөг бүхий 2 ширхэг хивс нь өөр байгууллагад ашиглагдаж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 26 дугаар зүйлд “Төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах” гэснийг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтаар “Үнэн зөв байх” гэж тодорхойлсныг зөрчсөн байна. Бодитой оршин байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 26 дугаар зүйлд “Төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах” гэснийг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтаар “Үнэн зөв байх”, бодитой оршин байх батламж мэдэгдлийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

### 2.9.2 Мөнгөн хөрөнгийн талаар

Бэлэг дурсгалын зүйлийг нийт 5.5 сая төгрөгөөр худалдан авсан нь холбогдох тогтоол, зааврыг дагаж мөрдөөгүй байна.


Энэ нь Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Бэлэг, дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам”-ыг хэрэгжүүлээгүй байна. Зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Бэлэг, дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам”-ыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн.

### 2.9.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг гэж заасныг хэрэгжүүлэх, 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасныг зөрчсөн байна.





**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 болон 18 дугаар зүйлийн 18.2-т заасныг мөрдөж ажиллах болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй болох талаар зөвлөмж өгсөн.

## 2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байгууллагын худалдан авах үйл ажиллагаанд ТБОНӨХБАУХАТ хууль болон ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллахад анхаарах. Тайлант оны 10 дугаар сарын 18-ны өдөр 47.0 сая төгрөгөөр хөрөнгийн бизнес үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажилласан байна. Гэрээний хугацаа дуусгавар болж 2017 оны 11 дүгээр сарын 13-нд гэрээ дүгнэсэн акт үйлдсэн боловч гэрээгээр хийгдсэн үнэлгээний тайланд засвар хийгдэх шаардлага гарч, засвар хийгдсний дараа 2018 оны 1 дүгээр сард төлбөрийг барагдуулсан байна.

## 2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Байгууллагын худалдан авах үйл ажиллагаанд ТБОНӨХБАУХАТ хууль болон Засгийн газрын 2013 оны 68-р тогтоолыг хэрэгжүүлж ажиллаж байгаа эсэхийг дараагийн аудитаар авч үзэх.

## 2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 12.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар удирдлагын анхааралд хандуулж 3 зөвлөмж өгсөн болно.

## 2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК нь 2017 оны 4 дүгээр сард байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Иймээс өмнөх оны санхүүгийн тайлангийн аудит хийгдээгүй болно.

## 2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2017 оны санхүүгийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс тооцсон. Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2 хувиар буюу 7.8 сая төгрөгөөр тогтоосон болно.

## 2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, хөрөнгийн үйлдвэр, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан зөвлөмж, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, СТОУС, НББОУС түүнд ашигдсан Санал дүгнэлтийн

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “ Зөрчилгүй ” санал дүгнэлт гаргалаа.



### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



**Асуудал 1: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**Ажиглалт**

Санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг, гэж заасныг хэрэгжүүлэх, 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасныг зөрчсөн байна.

**Зөвлөмж**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 болон 18 дугаар зүйлийн 18.2-т заасныг мөрдөж ажиллах болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж мөрдөх талаар зөвлөмж өгсөн.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Эрсдэлүүд**

Нягтлан бодох бүртгэлийн хуулийн заалт зөрчигдөж, санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх үүрэг батламжийн мэдэгдлүүд зөрчигдөх;

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



**Асуудал 2: Үндсэн хөрөнгийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**Ажиглалт**

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа нийт 6.5 сая төгрөгийн өртөг бүхий 2 ширхэг хивс нь өөр байгууллагад ашиглагдаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтаар “Үнэн зөв байх” гэж тодорхойлсныг зөрчсөн байна. Бодитой оршин байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланд бүртгэл алдаатай хөтлөгдөх, хөрөнгө үрэгдэх, чанар алдагдах;

**Зөвлөмж**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтаар “Үнэн зөв байх” гэснийг, бодитой оршин байх батламж мэдэгдлийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



**Асуудал 3: Мөнгөн хөрөнгийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №3**

**Ажиглалт**

Бэлэг дурсгалын зүйлийг 5.5 сая төгрөгөөр худалдан авсан нь холбогдох тогтоол, зааврыг дагаж мөрдөөгүй байна.

Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 2 дугаар хасралт “Бэлэг, дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам”-ыг хэрэгжүүлээгүй байна. Зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Эрсдэлүүд**

Зардал өндөр илэрхийлэгдэх, стандарт заавар, журмыг мөрдөхгүй байх;

**Зөвлөмж**

Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Бэлэг, дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам”-ыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын үйлчлүүлэгчийн санхүүгийн ажилтанд танилцуулсан болно. бүртгэлийг удирдлага,



#### 4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, зорилтот төвшин

##### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	<i>/төгрөгөөр/</i>	
	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
<b>ХӨРӨНГӨ</b>		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		101,180,587.35
Дансны авлага		2,730,000.00
Татвар, НДШ-ийн авлага		1,975,631.35
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		15,500,000.00
Бусад эргэлтийн хөрөнгө		737,154.88
Эргэлтийн хөрөнгийн дүн		122,123,373.58
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө		41,385,879.55
Биет бус хөрөнгө		5,538,566.20
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		46,924,445.75
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		169,047,819.33
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
Дансны өглөг		47,000,000.00
Цалингийн өглөг		843,165.02
Татварын өглөг		8,739,972.72
Урьдчилж орсон орлого		62,339,647.96
Богино хугацаат өр төлбөрийн дүн		118,922,785.70
Урт хугацаат зээл		
Урт хугацаат өр төлбөрийн дүн		
Өр төлбөрийн дүн		118,922,785.70
Өмч Төрийн		10,000,000.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц		
Хуримтлагдсан ашиг		40,125,033.63
Эздийн өмчийн дүн		50,125,033.63
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>		169,047,819.33



#### 4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Борлуулалтын орлого		438,635,100.04
Борлуулалтын өртөг		-
Нийт ашиг/алдагдал		438,635,100.04
Хүүгийн орлого		29,858.53
Бусад орлого		0.00
Ерөнхий ба удирдлагын зардал		363,141,333.45
Санхүүгийн зардал		663,000.39
Бусад зардал		27,039,059.00
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		-159,965.10
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал		47,661,600.63
Орлогын албан татвар		7,536,567.00
Татварын дараах ашиг/алдагдал		40,125,033.63

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**



### 4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Өмч	ҮХөр дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ашиг	/төгрөгөөр/
				Нийт дүн
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл				0.00
Залруулсан үлдэгдэл				0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				0.00
Өмчид гарсан өөрчлөлт				0.00
Зарласан ногдол ашиг				0.00
2016 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл				0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				0.00
Өмчид гарсан өөрчлөлт				0.00
НББ-ийн алдааны залруулга				0.00
Залруулсан үлдэгдэл				0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			40,125,033.63	40,125,033.63
Зарласан ногдол ашиг				0.00
2017 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	10,000,000.00		40,125,033.63	50,125,033.63



#### 4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Мөнгөн орлогын дүн		510,974,748.00
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Татаас, санхүүжилтийн орлого		510,974,748.00
Мөнгөн зарлагын дүн		360,279,144.08
Ажиллагчдад төлсөн		119,351,600.41
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		24,621,515.04
Бараа материал авахад төлсөн		19,649,500.00
Ашиглалтын зардалд төлсөн		2,451,706.87
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		3,406,000.00
Хүүний төлбөрт төлсөн		663,000.39
Татварын байгууллагад төлсөн		9,002,117.14
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө		
Бусад мөнгөн зарлага		181,133,704.23
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		150,695,603.92
Мөнгөн орлогын дүн		29,858.53
Худалдсан хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого		29,858.53
Мөнгөн зарлагын дүн		49,384,910.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		43,818,910.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		5566000
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-49,355,051.47
Мөнгөн орлогын дүн		10,000,000.00
Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө		10,000,000.00
Мөнгөн зарлагын дүн		10,000,000.00
Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас төлсөн мөнгө		10,000,000.00
Ногдол ашиг		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		0.00
Валютын ханшны зөрүү		(159,965.10)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		101,180,587.35
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		101,180,587.35



#### 4.5 Аудит хийгдсэн орлого, зардлын төлөвлөгөө гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
			Зөрүү	Биелэлт хувь
<b>II. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>				
Цалин хөлс	93,580,435.00	94,292,332.00	711,897.00	100.76%
Унаа, хоол хөнгөлөлт	18,720,000.00	17,760,000.00	(960,000.00)	94.87%
НДШ	12,353,048.00	12,299,397.00	(53,651.00)	99.57%
Бичиг хэргийн зардал	10,720,000.00	10,711,550.00	(8,450.00)	99.92%
Гэрэл, цахилгаан	2,090,000.00	1,887,411.00	(202,589.00)	90.31%
Түлш, халаалт	350,000.00	349,151.00	(849.00)	99.76%
Цэвэр, бохир ус	223,417.00	217,269.00	(6,148.00)	97.25%
Тээвэр (шатахуун)	6,406,000.00	6,406,000.00	-	100.00%
Шуудан холбооны зардал	6,500,000.00	6,494,755.00	(5,245.00)	99.92%
Дотоод албан томилолт	1,360,000.00	1,353,000.00	(7,000.00)	99.49%
Гадаад албан томилолт	71,900,000.00	71,842,269.00	(57,731.00)	99.92%
Зочин төлөөлөгч хүлээн авах	38,400,000.00	38,366,063.00	(33,937.00)	99.91%
Ном, хэвлэл захиалга, авах	2,200,000.00	2,207,133.00	7,133.00	100.32%
Эд хогшил худалдан авах	59,800,000.00	59,455,910.00	(344,090.00)	99.42%
Багаж хэрэгсэл	44,000,000.00	43,926,010.00	(73,990.00)	99.83%
Тавилга	10,000,000.00	9,890,900.00	(109,100.00)	98.91%
Програм хангамж	5,800,000.00	5,639,000.00	(161,000.00)	97.22%
Урсгал засвар	3,300,000.00	3,300,000.00	-	100.00%
Төлбөр хураамж болон бусад зардал	9,800,000.00	10,745,509.00	945,509.00	109.65%
Байрны түрээсийн хөлс	33,750,000.00	33,749,500.00	(500.00)	100.00%
Сургалт, хурал, зөвлөгөөний зардал	18,300,000.00	18,322,458.00	22,458.00	100.12%
Гадаад сургалт, семинарт суралцах	8,900,000.00	8,812,592.00	(87,408.00)	99.02%
Сургалт, семинар, хурал зохион байгуулах	9,400,000.00	9,509,866.00	109,866.00	101.17%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	121,225,500.00	121,215,040.00	(10,460.00)	99.99%
Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хөлс	111,000,000.00	110,985,780.00	(14,220.00)	99.99%
Тээврийн хэрэгслийн оношлогоо, засвар үйлчилгээ	6,400,000.00	6,400,200.00	200.00	100.00%
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,750,000.00	2,753,570.00	3,570.00	100.13%
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	75,500.00	75,490.00	(10.00)	99.99%
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.00%
<b>Зардлын нийт дүн</b>	<b>510,978,400.00</b>	<b>510,974,747.00</b>	<b>(3,653.00)</b>	<b>100.00%</b>

